

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2019



Агуулга

- ✧ Мэндчилгээ
- ✧ Тогтвортой хөгжлийн зорилго
- ✧ Бизнесийн хүрээ
- ✧ Бизнесийн ёс зүй
- ✧ Аюулгүй ажиллагаа
- ✧ Эрүүл мэнд
- ✧ Байгаль орчин
- ✧ Хүний эрх
- ✧ Нийгэм, эдийн засаг





Бизнесийн урт хугацааны амжилтын үндэс нь “Тогтвортой хөгжлийн зарчим”-ыг үйл ажиллагааны салшгүй хэсэг болгох юм.

Манай компани эрчим хүчний салбарт 26 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд бид байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдал болон ажиллагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг ямагт нэн тэргүүнд тавьж бизнесээ эрхлэхийн хажуугаар улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулан 200 гаруй төслийг хэрэгжүүлж энэ оны 12 дугаар сарын байдлаар нийт 793'271'800 кВт.цаг цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэж Ухаа худаг уурхай, Цогтцэций сум болон Төвийн эрчим хүчний системд нийлүүлжээ.

Дэлхийн чиг хандлага, Монгол улсын хөгжил, компанийн дэвшил болон ажиллагчдын мэргэшсэн чадварын өсөлттэй уялдан манай компани анх удаа НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгод тулгуурлан компанийн “Тогтвортой хөгжлийн тайлан”-г гаргаж харилцагч байгууллагууд, нийт ажиллагчид болон олон нийтэд хүргэж байгаадаа баяртай байна.

Бид энэхүү тайлангаар байгаль орчин, ажиллагчдын эрүүл мэнд болон ажлын байран дахь аюулгүй байдлыг эрхэмлэн ажиллаж, олон улсын жишигт хүрсэн компаниудын нэг байх, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах эрхэм үйлсэд компанийн үйл ажиллагаа хэрхэн нийцсэнийг харуулахаар зорилоо.

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах, сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах үүднээс:

-Үйлдвэрлэлийн орчны агаарын найрлагын өөрчлөлтийг стандартын түвшинд барьж,

-Усны хэрэглээг хамгийн бага түвшинд тогтоохоор зорьж, дахин ашиглалтыг дэмжин,

-Олон улсын эрчим хүчний стандартыг хэрэгжүүлэгч байгууллагуудын нэг болсон.

Байгалийн нөөцийг зохистойгоор ашиглах, эрчим хүчний хариуцлагатай хэрэглээг нэвтрүүлэх ажлын хүрээнд Ухаа худагийн цахилгаан түгээх сүлжээний тоног төхөөрөмжүүдийн эрчмийн алдагдлыг бууруулах, үр ашиггүй хэрэглээг багасгах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.

Монгол Улсын Нийгэм, Эдийн засгийн хөгжилд

бид дотоодын үйлдвэрлэгчид болон нийлүүлэгчдийг дэмжин, улс орныхоо эдийн засаг нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж сүүлийн 5 жилд улсын төсөвт нийт 63.4 тэрбум төгрөг төвлөрүүлснээс зөвхөн 2019 оны хувьд 20.9 тэрбум төгрөгийн татвар, хураамж төлжээ.

Энэ жил орон нутгийн ажиллагчдын тоог нэмэгдүүлж, нийгэм олон нийтэд чиглэсэн ажлуудад оролцоог нэмэгдүүлж, ажиллагчдынхаа аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, боловсрол болон сэтгэл ханамжийг дээшлүүлэх ажлын хүрээнд бид гадаадын томоохон компаниудтай хамтран ажиллахдаа суралцаж, баяжуулсан **аюулгүй ажиллагааны** арга барил болон хандлагыг өөрсдийн үйл ажиллагаанд цогцоор нэвтрүүлж, нийт 8000 орчим цагийн сургалт зохион байгуулахад 100 гаруй сая төгрөг зарцуулснаас гадна компанийн Ухаа худаг (УХГ) салбарын Цахилгаан станцын ажиллагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд 2021 он хүртэл нийт 51 байр олгохоор төлөвлөснөөс, эхний ээлжийн байруудыг гардуулан өгсөн байна.

Бизнесийн урт хугацааны амжилтын үндэс нь “Тогтвортой хөгжлийн зарчим”-ыг үйл ажиллагааны салшгүй хэсэг болгох юм.

Иймээс бид энэхүү тайланг өөрсдийн тогтвортой хөгжлийн зорилгын биелэлтийг үнэлэх болон сайжруулж байх зорилгоор жил бүр гаргах болно.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал

Ч.ДАВААХҮҮ

Тогтвортой хөгжлийн зорилго

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас (НҮБ) Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг олон нийтэд түгээж, ёс зүйтэй бизнес эрхэлдэг компани бүр байгаль орчин болон нийгэмд хувь нэмрээ оруулж, ирээдүйд өнөөдөртэй адил хэмжээний боломж, бололцоо болон нөөцийг өвлүүлэх үүднээс тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах болсон билээ.

М Си Эс Группийн хэмжээнд бид “Нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажилладаг” хамт олон байхаар Тогтвортой хөгжлийн зарчмаа тодорхойлсон.



М Си Эс Интернэйшнл компанийн үйл ажиллагаанд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн дараах 6 зорилго хэрэгжиж байна.





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Хүн бүр осол, зөрчил болон ёс зүйгүй үйлдлийг мэдээлэх бүрэн эрхтэй бөгөөд хууль журам, дүрэм болон стандартуудад нийцсэн үйл ажиллагаа эрхэлнэ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Бид нийгмийн үнэ цэнэд хувь нэмрээ оруулж, хариуцагчдынхаа эрх ашгийг хүндэлж, хариуцлагатай байгууллагын жишигт нийцэж ажиллана

ХҮНД ЧИГЛЭСЭН

Ажиллагчдын эрх ашгийг хүндэлж, боловсрол болон хувь хүний өсөлт хөгжилд анхаарна

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ

Компанийн хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагаанаас үүдэн гарсан аливаа нөлөөллийг бууруулах замаар байгаль орчныг хамгаална

АЖЛЫН БАЙРНЫ ЭРҮҮЛ МЭНД БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭСЭН

Ослоос урьдчилан сэргийлэх, ялангуяа хөдөлмөрийн чадвар түр алдсан гэмтлээс сэргийлэх нь бидний эн тэргүүний зорилт юм. Ажиллагчдын оролцоог нэмэгдүүлэх болон манлайлалд төвлөрсөн арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлснээр энэхүү зорилтдоо бид хүрэх болно.

ХӨГЖИЛ ДЭВШИЛ БОЛОН ИННОВАЦИД ТҮЛГҮҮРЛАСАН

Цаашид хамтдаа хөгжих зорилгод нэгдэж байгальд ээлтэй шийдлүүдийг эрэлхийлж, дэлхийн инженерингийн хөгжлийг Монголд нутагшуулна

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ СОНГОЛТЫГ ДЭМЖСЭН

Судалгаа шинжилгээний ажилд ач холбогдол өгч, сэргээгдэх эрчим хүчний эх сурвалжид дэлхий нийтээрээ шилжих явцад үргэлжлүүлэн хувь нэмрээ оруулна

Бид НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилтод өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа онцлогийг харгалзуулан үзэж, Компанийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон болно.

Доорх диаграмд М Си Эс Интернэйшнл ХХК-ийн зорилтууд болон М Си Эс Группийн баримтлах зарчмууд НҮБ-ын 17 зорилтоос нь 6-тай нь яв цав нийлж буйг харуулсан болно. Тус диаграм нь тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах салбарууд болох Нийгэм, Байгаль орчин болон ажиллагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал зэрэг чиглэлүүдэд түлхүү анхааран ажиллах алсын харааг тодорхойлж буй юм.



БИДНИЙ ТҮҮХ

М Си Эс Группийн ууган компани болох **М Си Эс Интернейшнл ХХК** нь 1993 онд эрчим хүчний зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлснээс хойш эрдэс баялаг, эрчим хүчний салбарын шинэчлэлт өөрчлөлт хийхэд идэвхитэй оролцон, орчин үеийн шинэ техник технологи бүхий цогц шийдэл боловсруулах, түүнийг нэвтрүүлэхэд түлхүү анхаарч, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа үндэсний тэргүүлэх инженерингийн компани юм.



Дорноговь аймаг, Замын-Үүд
"Гэгээн" 15МВт-н нарны цахилгаан станц

Оюу толгойн дулааны цахилгаан станцын өргөтгөлийн төслийг амжилттай гүйцэтгэв. Олон улсын Нэгдсэн Удирдлагын Тогтолцоо (ISO 9001:2015, ISO14001:2014, ISO 45001:2018, ISO 50001:2018) -г үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.

Сайншанд 55МВт СЛС-ын төсөлд амжилттай оролцов. Замын үүдийн "Гэгээн" 15 МВт, Шинэ нисэх буудлын "Бөхөг" 15 МВт нарны цахилгаан станцын төслүүдийг амжилттай хэрэгжүүлэв

Оюу толгой далд уурхайн бүтээн байгуулалтанд амжилттай оролцов

Цэций 50 МВт-ын салхин цахилгаан станцын төсөлд амжилттай оролцов

Монгол улсад мега төслөөр нэрлэгдсэн Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 220кВ ийн, 400 км ЦДАШ төслийг амжилттай гүйцэтгэв

Монгол инженерүүдийн бие даан барисан, анхны Цахилгаан станцын төслийг амжилттай хэрэгжүүлэв. Ухаа худаг уурхай болон Цогцэций суманд цахилгаан эрчим хүч нийлүүлэх салбар байгуулагдав

Эрчим хүчний туршилт үйлдвэрлэлийн ЭВА төв байгуулагдав

Цахилгаан түгээх, хангах үйлчилгээний Эрчим Сүлжээ ХХК байгуулагдав

Шинэ техник, технологи, тоног төхөөрөмж таниулж, сурталчилах Эрчим технологийн төв байгуулагдав


М Си Эс Интернэйшнл ХХК-ийн Эрчим хүчний газар байгуулагдав
Дулаан хангамжийн чиглэлээр ажиллах Энержо компани байгуулагдав

М Си Эс Группийн ууган компани болох М-Си-Эс Интернэйшнл ХХК байгуулагдаж, зөвлөх үйлчилгээ үзүүлж эхлэв

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ САЛБАРУУД



БИДНИЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД



“ТАЙШИР” усан цахилгаан станц



“УХАА ХУДАГ” 18 МВт цахилгаан станц



Оюу Толгой Δ ЦС өргөтгөл



АВТОМАТЖУУЛААЛТЫН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ



ХАЛААЛТЫН СИСТЕМ, ЗУУХНЫ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨЛ



“ЦЭШИЙ” 50 МВт салхин цахилгаан станцын төсөл



БУЛГАН – МӨРӨН 110 кВ ЦДАШ, дэд станцын төсөл



ОЮУ ТОЛГОЙ ДАЛД УУРХАЙН чухал барилга байгууламж бүтээн байгуулах төсөл



МАНДАЛГОВЬ – ТАВАНТОЛГОЙ – ОЮУТОЛГОЙ 220 кВ ЦДАШ, дэд станцын төсөл



Замын-Үүд “ГЭГЭЭН” 15МВт-ын нарны цахилгаан станцын төсөл



Сайншанд “САЛХИН ПАРК” 55МВт-ын салхин цахилгаан станцын төсөл



Хөшигийн хөндий “БӨХӨГ” 15МВт-ын нарны цахилгаан станцын төсөл

Нэгдсэн удирдлагын ТОГТОЛЦОО

М Си Эс Интернэйшнл ХХК нь эрчим хүчийг хэмнэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, эрүүл аюулгүй ажиллагааг хэвшүүлэх болон оролцогчдын сэтгэл ханамжид нийцүүлэх чиглэлийг барьж ажилладаг.

“Нэгдсэн удирдлагын тогтолцоо”-ны шаарлагуудад бүрэн нийцсэн үйл ажиллагаа явуулж буйгаа Олон улсын магадлан итгэмжлэлийн форум буюу “International Accreditation Forum” болон Австрали-Шинэ Зеландын бүсийн “JAS-ANZ” байгууллагаар итгэмжлэгдэж, Австралийн “BCert” компаниар баталгаажсан олон улсын стандартын гэрчилгээгээр 2019 онд баталгаажуулсан юм.

ISO 45001:2018

ISO 50001:2018

ISO 14001:2015

ISO 9001:2015

Эрсдэлийн удирдлага

М Си Эс Интернэйшнл компани өөрийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг амжилттай биелүүлэх зорилгоор эрсдэлээ удирдах ажиллагааг хэрэгжүүлж байна.



М Си Эс Интернэйшнл компани эрсдэлийг удирдах үйл ажиллагаандаа Эрсдэлийн удирдлагын журам, Эрсдэлийн удирдлагын гарын авлагыг удирдлага болгон **ARM** системийг хэрэглэдэг.

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд компанийн **бүх ажилтан, ажиллагсад** оролцдог бөгөөд энэ нь жижиг гэлтгүй бүх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг багасгаж, хянах ач холбогдолтой.

Бизнесийн ёс зүй

М Си Эс Интернэйшнл компани бизнесийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалтыг мөрдөн ажиллахыг онцгой анхаардаг. Бид М Си Эс Группийн “Ёс зүйн дүрэм”-ийг удирдлага болгон Монгол улсын хууль, тогтоомжийг алхам тутамдаа дээдлэн, хууль, эрх зүйн актад тавигдсан шаардлага болон Захиалагчийн зүгээс тавигдах хууль ёсны шаардлагыг ханган, үнэнч шударгаар ажилладаг.

- ✘ Бизнесийн ёс зүйг эрхэмлэдэг, хууль дүрэм, стандартуудтай нийцүүлэн ажилладаг
- ✘ Бүгдийн эрх ашгийг эрхэмлэдэг
- ✘ Ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, дээрэлхэн сүрдүүлэлт, гүтгэлгээс ангид
- ✘ Харилцагч болон бэлтгэн нийлүүлэгч нартаа ижил тэгш боломж, бололцоо олгодог
- ✘ Өрсөлдөгч нартаа шударга ханддаг
- ✘ Ашиг сонирхлын зөрчлийг үл зөвшөөрдөг.





М Си Эс Интернэйшнл ХХК нь бүх ажиллагчид, туслан гүйцэтгэгчдийн эрүүл аюулгүй байдлыг ханган ажиллахыг зорьдог ба үүний хүрээнд бид аюулгүй ажиллагааны дүрэм журмыг боловсруулан үйл ажиллагааг системчлэх, аюулгүй ажиллагааны соёлыг бэхжүүлэх, Олон улсын туршлагыг нэвтрүүлэх, манлайлын болон эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг зохион байгуулах зэрэг ажлуудыг тасралтгүй сайжруулан хийж байна. Компанийн хэмжээнд төслийн нэгжүүд болон УХГ салбар болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны (ХАБЭАБО) албатай нэгдсэн тогтолцооны хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

ХАБЭАБО

ГОЛ ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙН ЗОРИЛТ БОЛОН БОДИТ ҮЗҮҮЛЭЛТ

Бид бүх осолд дөхсөн тохиолдол болон гарсан осол зэргийг мэдээлж, бүртгэн судалдаг. Ингэснээр осол бүрт тохирсон хариу арга хэмжээг авч дахин осол гарахаас сэргийлэх, жил бүрийн зорилтоо тодорхойлох суурь үзүүлэлт болгон, тасралтгүй сайжруулалтыг хийдэг. 2019 онд 1 удаа эмнэлгийн тусламж авсан осол бүртгэгдсэнээс бусад зорилтуудад хүрсэн, хөдөлмөрийн чадвар түр алдсан болон нийт гэмтэл бэртлийн давтамжийг өнгөрсөн оныхоос 71-80 хувиар бууруулсан амжилтыг гаргажээ.

Зорилт



Амь нас эрсдэж болзошгүй осол (PFI)-ыг **0** байлгах



2019 онд ХЧТАОД (LTIFR)-ийг **0.36**-аас бага түвшинд байлгах



Ноцтой осолд дөхсөн тохиолдол (SI)-ыг **0** байлгах



Эмнэлгийн тусламж авсан ослын тохиолдол (MTCI) гаргахгүй байх



Анхны тусламж авсан тохиолдол (FAC)-ын тоог **18**-аас хэтрүүлэхгүй байх



Байгаль орчинд бохирдол үүсгэсэн тохиолдол (EI)-ыг **1** – ээс илүүгүй байлгах



Эд хөрөнгийн эвдрэл гарсан тохиолдол (PD)-ыг **10**-аас хэтрүүлэхгүй байна

Бодит үзүүлэлт

Зорилтын хүрээнд сайжруулалтын ажлууд хийгдэж энэ төрлийн осол гарахаас сэргийлж чадсан

Хөдөлмөрийн чадвар түр алдсан ослын давтамж **0.07** байсан.


Ноцтой осолд дөхсөн тохиолдол гараагүй

Эмнэлгийн тусламж авсан ослын **1** тохиолдол гарсан

Анхны тусламж авсан тохиолдлын тоо **17** байгаагаас нүд болон хуруу гарны гэмтэл хамгийн түгээмэл байсан тул 2020 онд хуруу гарны гэмтлээс сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөсөн


Хөрсний бохирдол үүсгэсэн осол гараагүй

Эд хөрөнгийн эвдрэлийн тохиолдол **6** гарсан



Хөдөлмөрийн чадвар түр алдсан ослын давтамж

2018 онд 0.36 үзүүлэлттэй байснаас 2019 онд **80%**-аар буурсан



Нийт бэртэл гэмтлийн давтамж

2018 онд 0.48 үзүүлэлттэй байснаас 2019 онд **71%**-аар буурсан



УХГ цахилгаан станц
Өмнөговь аймаг,
Цогтүвший сум

ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ БАГАЖНЫ ҮР ЧАДВАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Энэ ажлын хүрээнд 2019 оны байдлаар 34 хүн (давхардсан тоогоор), 5 төрлийн багажны үр чадварын баталгаажуулалт хийжээ.

 34
 5

Өндөр эрсдэлтэй багаж ашиглаж ажлаа гүйцэтгэдэг ажиллагчдынхаа аюулгүй ажиллагааг хангах үүднээс бид үр чадварын баталгаажуулалт хийдэг. Үр чадварын баталгаажуулалтын хүрээнд ашиглах багажны танилцуулга, зааврыг уншиж танилцах, холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх, туршлагатай ажилтан зөвлөгөө өгөх, шалгалт аван баталгаажуулалт хийх зэрэг зүйлс багтдаг.



ААД
ТАД

Цахилгаан болон дулаан үйлдвэрлэх байгууламжид ажиллахдаа өөрийн болон хамтран ажиллагчдынхаа аюулгүй ажиллагааг эрхэмлэн ажилладаг. 2019 оноос эхлэн Монгол улсад мөрдөгддөг “Аюулгүй ажиллагааны дүрэм” (ААД), “Техник ашиглалтын дүрэм”-ийн (ТАД) мэдлэгийн шалгалтыг инженер техникийн ажиллагчдаас **ЦАХИМ** хэлбэрээр авч эхэлсэн нь тэдгээрийн мэдлэгийн түвшинг бодитоор үнэлэх, цаг хугацаа хэмнэх зэрэг давуу тал, ололттой байлаа.

ТУСГААРЛАЛТЫН ЖУРАМ

Эрчим хүчний салбарт өмнө учирч байсан болон тохиолдох боломжтой эрсдлүүдийн мэдээлэл, түүнээс авсан сургамжид үндэслэн Тусгаарлалтын журмыг нэвтрүүлж эхлээд байна. Энергийн эх үүсвэрийг бүрэн тусгаарлаж салгасныг баталгаажуулах нь ажилтанд ажлаа аюулгүй гүйцэтгэх боломжийг бий болгодог.

НИЙТ АЖИЛЛАГСДЫН
МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ

180

1-р зэргийн
ТУСГААРЛАЛТЫН
ажилтны сургалт

61

2-р зэргийн
ТУСГААРЛАЛТЫН
ажилтны сургалт

21

ажиллагч тус тус хамрагдсан байна.

Ажлын байрны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор явуулдаг бидний үйл ажиллагаанаас...

Эрүүл мэндийн өдөрлөгүүд

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон тогтмол үзлэг

Эрүүл мэндэд чиглэсэн журамнууд

Спортлог өдрүүд

Дасгал хөдөлгөөнийг дэмжих цаг

Бүх ажиллагсадын хамруулсан даатгалууд

Компанийн нийт ажиллагчид тогтмол хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг ба 2018 оны байдлаар нийт

370 хүн
105.6 сая ₮

үнийн дүнтэй эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

Ажлын байрны онцлогоос шалтгаалан үйлдвэрлэлийн ослын даатгалыг

₮ 15-24 сая

төгрөгөөр ажиллагч бүрт хийлгүүлжээ.



Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөг багасгах чиглэлийн ажиллагаа

Сэргээгдэх эрчим хүч

М Си Эс Интернэйшнл ХХК нь 2016-2018 онууд нийт 30МВт суурилагдсан хүчин чадалтай 2 Нарны цахилгаан станц, нийт 105МВт суурилагдсан хүчин чадалтай 2 Салхин цахилгаан станцын бүтээн байгуулалтанд Гүйцэтгэгчээр ажилласан.

Агаарын бохирдолд нөлөөлөх хүчин зүйлсийг багасгах чиглэлд

М Си Эс Кока Кола үйлдвэр дулааны эрчим хүчээ уламжлалт, нүүрсээр ажилладаг халаалтын зуухны технологиор шийддэг бөгөөд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах болон тогтвортой байдлын зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор *Шингэрүүлсэн нефтийн хийгээр* ажилладаг, байгаль орчинд хор нөлөөгүй зуухнуудыг суурилуулж, ашиглалтанд оруулах юм. Тус төслийг М Си Эс Интернэйшнл ХХК хэрэгжүүлж байна.

Агаарын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг хянах ажлын хүрээнд УХГ Цахилгаан станцыг (ЦС) сүүлийн үеийн дэвшилтэт технологийн цахилгаан статик уутат шүүлтүүрээр тоноглогдсон бөгөөд энэхүү цахилгаан шүүлтүүр нь утааны хийд агуулагдах нарийн ширхэглэгт үнсийг 99,9 хүртэл шүүдэг. Ингэснээр ЦС-ын яндангаас гарах утааны хийд агуулагдах үнслэгийн хэмжээг хамгийн бага түвшинд барих бөгөөд тус шүүлтүүр нь цахилгаан

бага зарцуулдгаараа давуу талтай.

Тус станцын эргэлтэт буцламтгай давхаргат, дундын циклонтой зуух нь нүүрсийг цельсийн 1,000 градусаас доош хэмд шатаадаг шаталтын технологитой. Энэ нам температурт шатаах технологи нь NOx, SO2, CO зэрэг байгаль орчинд хаягдах хорт бодисын хэмжээг хамгийн бага хэмжээнд ялгаруулдаг тул бид сонгон авч суурилуулсан.

Усны хэрэглээг багасгах чиглэлд

Уламжлалт технологийн станцууд нь турбинд ажилласан уурыг задгай систем бүхий (градерн) агаар усны технологиор хөргөдөг. УХГ цахилгаан станцын хувьд усны "О" хэрэглээ бүхий агаарын хөргөлттэй конденсатор суурилуулсан бөгөөд уламжлалт технологитой харьцуулбал нийт усны хэрэглээ 8-9 дахин бага байгаа нь усны нөөц багатай говийн нөхцөлд хамгийн тохиромжтой систем юм.

Говийн нөхцөлд ус хэмнэх зорилгоор суурилуулсан бас нэг технологи нь үнсийг хуурайгаар зайлуулах систем юм. Үнсийг хуурайгаар зайлуулснаар уламжлалт технологи бүхий станцтай харьцуулбал жилд дунджаар хоёр сая ба түүнээс их тонн усыг хэмнэж байна.

Хог хаягдлыг багасгах чиглэлд

18 МВт-н хүчин чадалтай УХГ цахилгаан станц түлш болон хаягдал тосны хадгалалтаас үүсч болзошгүй асгаралтаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг. Мөн хаягдал тос хадгалах цэгийг цэвэрлэж, хашаатай болгож, тогтмол хяналт тавьж ажилладаг.

Оюу Толгой төслийн Дулааны төв станцын өргөтгөлийн төслийг М Си Эс Интернэйшнл 2018-2019 оны хооронд гүйцэтгэсэн бөгөөд төслийн талбайд хогийг ангилан хаях аян зохион байгуулах, ажиллагчдыг урамшуулах зэргээр хог хаягдлын тархалтыг хянах арга хэмжээ авч байсан бөгөөд өдгөө тус арга хэмжээг М Си Эс Интернэйшнл компани салбар болон төслүүддээ байнга хэрэгжүүлж байна.

Эрчим хүчийг хэмнэх чиглэлд

УХГ станцын дотоод хэрэгцээний эрчим хүчний хэрэглээг бууруулахын тулд бид станцын тоноглолуудыг давтамж хувиргуураар тоноглогдсон. Үүний үр дүнд бид ЦС-ийн дотоод хэрэгцээг 10%-д барьж ажиллаж байгаа нь Монгол улсын бусад цахилгаан станцтай харьцуулахад тэргүүлэх өндөр үзүүлэлт юм.

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ

УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Цахилгаан станцын технологийн хаягдал усыг төслийн талбайн хөнгөн тэрэгний зам усалгаа, уурхайн технологийн зам болон станцын гадаад талбайн ногоон байгууламж услахад эргүүлэн ашигласан бөгөөд үүний үр дүнд нийт 54,573 тн орчим цэвэр усыг хэмнэсэн байна. Хүйтний улиралд технологийн хаягдал усыг хаягдлын бакнаас 18 мЗ багтаамжтай автомашинаар зөөвөрлөн зам усалгаанд ашигласан бөгөөд илүүдэл усыг уурхайн технологийн зам усалгааны саванд (зүмф) төвлөрүүлж байна.

ХАЯГДАЛ УСНЫ ДАХИН АШИГЛАЛТ



ХӨРСНИЙ БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ

Түлш болон хаягдал тосны хадгалалтаас үүсч болзошгүй асгаралтаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна. Хөрсний бохирдол үзүүлж болзошгүй уг цэгээс дээж авч микроэлементийн шинжилгээ хийлгэсэн үр дүн стандартын шаардлага хангаж байв. Мөн хаягдал тос хадгалах цэгийг цэвэрлэж, хашаатай болгож, хяналтыг сайжруулав.

НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ БИЙ БОЛГОХ АЖИЛ

Ухаа Худагт үйл ажиллагаа явуулдаг компаниудын дунд ногоон байгууламжийн бүтээмжээрээ эрүүл орчныг бүрдүүлэн, тэргүүлж ажиллалаа. УХГ-ын Цахилгаан станц болон дэд станцын орчмоор 2010 оноос хойш нийт 15,541.6м² талбайд ногоон байгууламж бий болгож ажилласан байна. Үүнд:

3,505 ширхэг мод бут сөөг, зүлэг 1,852.4м² талбайд тарьсны ургалт 86% байна.


Мөн намар зүлэг, сухай, харгана, цэцгийн мандал зэргийн үрийг түүж дараа жил дахин тариалт хийх замаар ногоон байгууламжаа өргөтгөж ажилладаг.



Бид ажилтан бүр өөрийн тарьсан модтой байх зорилттой бөгөөд, шинээр ажилд орсон 26 ажилтан энэхүү зорилтыг дэмжиж нийт 118ш мод тарьсан байна.


ЦАХИЛГААН СТАНЦЫН УТААНЫ НАЙРЛАГЫН ХЭМЖИЛТ

Цахилгаан станцын яндангаас ялгарч байгаа утааны хийн найрлагыг цахилгаан станцад 3-10 саруудад хийж гүйцэтгэсэн. Утааны найрлагын хэмжилтээр агаарыг бохирдуулагч гол гурван хий болох нүүрс хүчлийн дутуу исэл **CO**, азотын исэл **NO_x**, хүхрийн исэл **SO₂** зэргийн утгыг голчлон хянаж байна. Багажаар хэмжсэн утгыг хэвийн агаарын түвшинд шилжүүлэн Монгол улсын стандарт MNS 5919:2008 –тай харьцуулан гаргадаг. Хэвийн агаарын нөхцөл буюу стандарт нөхцөл гэдэг нь зуухны утааны даралт 101,325 Па (760 мм м.у.б), температур 273 К (0°C), илүүдэл агаарын коэффициент 1.4 байх нөхцөл юм.




2019 оны 1 дүгээр улиралд утааны хийн найрлага дахь хүхрийн давхар ислийн хэмжээ MNS 5919:2008 стандартаас давсан үзүүлэлт гарсан тул агаар халаагчийн гэмтлийг засах, ялгах циклоны металл хийцийг засах, галын хотлын согло солих зэрэг засвар үйлчилгээг хийснээр агаарын зарцуулалт горимын үзүүлэлтэд хүрч, шаталтын горим хэвийн болж, механик дутуу шаталт буурч, хүхрийн давхар ислийн хэмжээ стандарт түвшинд хүрсэн байна.

Цахилгаан станцын утааны
хийн найрлага дахь CO



Цахилгаан станцын утааны
хийн найрлага дахь NO_x



Өнөөдрийн байдлаар УХГ цахилгаан станцын утааны найрлага дахь

- угаарын хий стандарт хэмжээнээс 8 дахин бага
- азотын исэл стандарт хэмжээнээс 3,5 дахин бага
- хүхрийн давхар исэл стандарт хэмжээнээс тогтмол бага болсон үзүүлэлттэй байна.

Манай компани хүний эрх болон ажиллагчдын хөгжилд ямагт онцгой анхаарал тавьж ирсэн. Бизнесийн уламжлалт хандлагаас орчин үеийн “Good corporate citizen” хандлагад шилжиж ажиллагчдынхаа ажлын орчныг ая тухтай байлгахыг бид эрмэлздэг.


Бид:

- Үйл ажиллагаатай холбоотой бодлого, дүрэм журмыг боловсруулахдаа хүний эрхийн асуудлыг анхаарч үздэг
- Хөдөлмөрийн харилцаанд тэгш боломж олгох болон үнэнч шударга байх зарчмыг эрхэмлэдэг
- Ажиллагчдыг тасралтгүй сурч, боловсроход нь үргэлж анхаарч дэмждэг
- Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийг дэмждэг
- Хүйсийн тэгш байдлыг хангаж, ялгаварлан гадуурхалтаас ангид орчныг бүрдүүлэхээр зорьж байна
- Байгууллагын эерэг соёлыг түгээн бэхжүүлдэг



СУРГАЛТ ХӨГЖИЛ

Сургалтын цаг




НИЙТ

816 Ажилтан сургалтанд хамрагдсан


Сургалтын зардал
₮ 129,8M

9'272
Сургалтын цаг (хүн.цагаар)

Сургалтын зардал/төрлөөр/



✧ БАЙГУУЛМАГЫН СОЁЛЫН СУДАЛГАА-ны үр дүн 2018 онд 3% өссөн



LEADERSHIP PROGRAM

Бид ажиллагчдынхаа амьдралын чанарыг дээшлүүлэх, тэдний тасралтгүй суралцах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оноос “Манлаймын цогц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд салбар бүрт амжилттай ажиллаж байгаа эрхэмүүдийг урьж, кофе уунгаа сонирхолтой яриа өрнүүлэн тус зочноор дамжуулан ажиллагчдад мэдлэг, мэдээлэл түгээх зорилго бүхий “MCSI Sunrise” өглөөний үулзалтыг тогтмол хийж байна.

MCSI SUNRISE

INSPIRATION

Өнөөдрийг хүртэл бид нийт 4 зочинтой үулзаад байгаа ба үулзалт бүр өөр өөрийн онцлог сэдэвтэй байдаг. Тухайлбал, хамгийн эхний зочин маань яагаад ном унших хэрэгтэй, хувийн хөгжил хаанаас эхэлдэг талаар бидэнтэй ярилцсан бол дараа дараагийн зочид маань өөрийн туршлагаар олж мэдсэн амжилтын томъёо, эрүүл, зөв амьдралын хэв маяг, ажил амьдралын тэнцвэр ба сэтгэлзүйн эрүүл мэндийн талаар мэдлэг, мэдээлэл өгсөн юм.



“Манлаймын хөтөлбөр”-өөс гадна ажиллагчдынхаа ажил амьдралын тэнцвэрийг хадгалах, сэтгэл ханамжтай, тайван ажлаа хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор уян хатан цагийн хуваарьт шилжсэн ба ингэснээр ажилтан бүр өөрийн ажил болон хувийн амьдралыг зохицуулан, бүтээмжтэй ажиллах нөхцөл бүрдсэн юм.

УХАА ХУДАГ САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 17 байр, 2021 он хүртэл нийт 51 байр олгохоор төлөвлөсний, эхний ээлжийн байруудыг гардуулан өгөөд байна. Хөтөлбөр хэрэгжсэнээр ажиллагчид тав, тухтай орчинд гэр бүлтэйгээ ажиллаж, амьдрах боломжийг олгосон чухал ач холбогдолтой юм.



Орон нутгийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх санаачлагын хүрээнд бид үйл ажиллагаагаа явуулдаг бүс нутгийн ажиллагчдыг дэмжин ажилладаг. Өдгөө манай компанид Өмнөговь аймгаас 48 хүн ажиллаж байна.



Тэгш эрх, боломж бололцоог дэмжин ажиллах үүднээс өдгөө бид Бүрэн дунд боловсролтой 20, бүрэн бус дунд боловсролтой 9 хүнийг ажлын байраар хангаж, нэг баг болон ажиллаж байна.



ОЮУТОЛГОЙ ТӨСЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ХАМТ ОЛОН



Бид энэ онд Оюу Толгой ХХК-ийн **ТА БИДНИЙ БАХАРХАЛ** амжилт сайшаах хагас жилийн арга хэмжээний **“ТЭРГҮҮЛЭХ ХАМТ ОЛОН”** шагналын эзэд болов.

2018-2019 оны хооронд амжилттай хэрэгжүүлж дуусгасан Оюу Толгой Дулааны Төв Станцын өргөтгөлийн төсөлд М Си Эс Интернэйшнл ХХК нь WORLEY компанийн (өмнөх нэршлээр Jacobs) удирдлаганд үндсэн гүйцэтгэгчээр ажилласан билээ.

Богино хугацаанд бид олон улсын мэргэжилтнүүдтэй хамтран соёлын ялгаа, хэлний бэрхшээлийг давж чадсанаараа аюулгүй ажиллагааны зөв зан үйлийг төлөвшүүлж, ажлын байран дээр эерэг уур амьсгалыг бий болгож, ажлын гүйцэтгэлээ сайжруулснаар бид хүнээ дээдэлдэг компани болохоо баталлаа.

Ажиллагчид өөрсдийн мэдлэг, туршлагаа бусдадаа нээлттэйгээр харамгүй хуваалцаг нь нийт ажиллагчдын чадавхийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулдаг.

Нийгэм, эдийн засаг

Нийгэм, эдийн засгийн хөгжилд бид түүштай хувь нэмрээ оруулсаар ирсэн. Татварыг хугацаанд нь төлж, дотоодын худалдан авалтыг үргэлж дэмжиж, сайн дурын ажлуудад идэвхитэй хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Бидний төлсөн татварын дүн өнгөрсөн жилүүдэд:

2016	2016	2017	2018	2019
6,807,321,038.66	6,045,260,607.16	14,831,951,419.92	14,809,740,585.73	20,906,735,078.52

Бид сайн дурын ажлыг дэмжигч

М Си Эс Интернэйшнл ХХК ийн ажилчид **ИД ШИДИЙН ОРОН 2** болон Цэцээ Гүн Ротаракт клубын Carebox зэрэг төслүүдэд хандив өгөв



ШУТИС-д М Си Эс Интернэйшнл ХХК-н нэрэмжит танхимыг тохижуулан хүлээлгэн өгөв.



ШУТИС, ЭХС
Улаанбаатар хот

Бид үндэсний үйлдвэрлэлээ дэмжигч:

2019 оны дотоодын худалдан авалт нийт дүн **115,950,298**

Энэхүү тайланг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилт болон Global Reporting Initiative (GRI) байгууллагын дэлхий нийтээр мэдээлмээ тайлагнах стандартыг чиглэл болгон гаргалаа.

Бид энэхүү тайлантай холбоотой санал хүсэлт болон асуултуудыг Munkhsuld.g@mcsi.mn цахим хаягаар хүлээн авахдаа таатай байх болно.



Веб: www.mcsi.mn
Утас: (976) 77226262
Монгол улс, 14241, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла
оффис, 7 давхар

Фото зургийг:

- **Ж.Ганхуяг** /М Си Эс Интернэйшнл ХХК, Ээлжийн инженер/
- Оюутолгой Олон нийттэй харилцах хэлтэс